

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 06 дугаар сарын 13-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3-9

1.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/	3-9
--	-----

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 06 дугаар
сарын 13-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга Т.Энхтүвшин ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 17 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 52.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 15 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: А.Адъяасүрэн, Ц.Анандбазар, Ж.Бат-Эрдэнэ, Ш.Раднаасэд, Ц.Туваан.

Нэг.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, мэргэжилтэн Э.Цолмон, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Отгонцэцэг, Барилга, хот байгуулалтын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Э.Ганхүү, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, мөн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ч.Сугармаа, Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Ш.Гүнсэндарь, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн захиргаа удирдлагын газрын Санхүүгийн хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, Эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Насантогтох, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Г.Энхтүвшин, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, мөн газрын Гүйцэтгэл нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Ууганцэцэг, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт С.Төрмөнх, Ч.Сарантуяа нар байлцав.

Төсвийн төслийн танилцуулгыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Улсын Ерөнхий аудиторов орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг нар танилцуулав.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Танилцуулга болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Ж.Батжаргал, О.Цогтгэрэл нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 26 минут үргэлжилж, 17 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 70.6 хувийн ирцтэйгээр 16 цаг 41 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Т.ЭНХТҮВШИН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 06 дугаар сарын 13-ны өдөр,
Мягмар гараг Төрийн ордон
“Их эзэн Чингис хаан” танхим
16 цаг 15 минут.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023
ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ 06 ДУГААР
САРЫН 13-НЫ ӨДӨР/МЯГМАР
ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Т.Энхтүвшин: Гишүүдийнхээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Тэгээд Байнгын хороонд оролцож байгаа гишүүдийг ирцийг танилцуулъя.

Амартүвшин гишүүн ирсэн байна. Аубакир гишүүн ирсэн байна. Батжаргал гишүүн ирсэн байна. Батлут гишүүн ирсэн байна. Ганбаатар гишүүн ирсэн байна. Дамдинням гишүүн ирсэн байна. Наранбаатар гишүүн ирсэн байна. Тэмүүлэн гишүүн ирсэн байна. Цогтгэрэл гишүүн ирсэн байна.

Ирц 52,9 хувьтай байгаа учир Байнгын хорооны хуралдааныг эхлүүлъя.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэндээ танилцуулъя.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдөр өргөн мэдүүлсэн 2 дахь хэлэлцүүлэг. Санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ гэж заасан байж байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад саналтай гишүүн байна уу? Алга байна.

Төсвийн тодотголын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Булгантуяа, Сангийн дэд сайд Мөнгөнчимэг, Мөнгөнчимэг сайд байна уу? Монгол Улсын Ерөнхий аудитор Занданбат, Занданбат байна уу. Монгол Улсын Ерөнхий аудитын орлогч албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Наранчимэг, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Самбууням, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Энхболд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албыг түр орлон гүйцэтгэгч, Бодлого төлөвлөлтийн газрын дарга Хишигбаяр, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ганбат, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Чимэдсүрэн, Чимэдсүрэн байна уу? Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Золбоо, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Алимаа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүл бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Баярмаа, Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Одонтуяа, Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Дэлгэржаргал, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга Бат-Эрдэнэ, Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн Төгөлдөр, Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн Цолмон, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн Дэнсмаа, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

мэргэжилтэн Энхманлай, Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Цолмон гэсэн дээрх хүмүүс оролцож байгаа юм байна.

Байнгын хорооны эрхлэх асуудлын хурээнд хамаарах яамнуудыг танилцуулъя.

Барилга, хот байгуулалтын яам. Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ганхүү, Зам, тээврийн хөгжлийн яамнаас танилцуулъя. Төрийн нарийн бичгийн дарга Батболд, Авто замын Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Сугармаа, Бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Гүнсэндарь, Уул уурхайн яам Төрийн захиргаа удирдлагын газрын Санхүүгийн хэлтсийн дарга Отгонцэцэг, ХААЯ-ыг танилцуулъя Төрийн нарийн бичгийн дарга Жамбалцэрэн, Бодлого төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Отгонцэцэг, Эрчим хүчний яам Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Насантогтох, Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Энхтүвшин.

Дээрх бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг хуралдуулна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын төслийн талаарх танилцуулгыг Булгантуяа сайд танилцуулах уу. Булгантуяа сайдыг урьж байна.

Х.Булгантуяа: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас экспортыг эрчимжүүлж, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, эдийн засгийг сэргээхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттай авсны үр дүнд эдийн засаг 2023 оны 1 дүгээр улиралд 7,9 хувиар өсөж, гадаад валютын албан нөөц энэ оны эхний 5 сарын байдлаар 3,8 тэрбум ам долларт хүрч сайжраад байна. Хэдийгээр эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд эерэг өөрчлөлтүүд гарч эхэлсэн боловч гадаад хүчин зүйлийн

нөлөөгөөр инфляц төдийлөн буурахгүй, иргэдийн бодит орлогод нөлөөлж байгаа тул ард иргэдийн орлого, амьжиргааг дэмжих зайлиггүй шаардлагыг бий болгож байна.

Дээр дурдсан эдийн засаг, нийгмийн нөхцөл байдалтай уялдуулан Монгол Улсын Засгийн газраас иргэдийнхээ орлогын баталгаа, амьдрах орчныг сайжруулах, хотын түгжрэлийг бууруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төсвийн тодотголын төсөлд тусгалаа. Тухайлбал, хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хүсэлт гаргасан өрхийн хүүхэд бүрд олгохын зэрэгцээ хүүхдийн мөнгөнөөс хасагдсан өрхийн хүүхдэд нөхөж олгох, тэтгэврийн зөрөөний асуудлыг цалингийн суурь итгэлцүүрийг шинэчлэх замаар шийдвэрлэх, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх, төрийн албаны цалингийн тогтолцоог шинэчилж, суурь цалингийн хэмжээг нэмэгдүүлэх, нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлж, авто замын сүлжээг өргөтгөх зэргээр нийслэлийн түгжрэлийг бууруулах арга хэмжээг төсөв хооронд зохицуулалт хийж шийдвэрлэхээр төсвийн тодотголын төсөлд тусгаад байна.

Төсвийн тодотголын арга хэмжээний үр дүнд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 1,7 их наяд төгрөгөөр, нэгдсэн төсвийн нийт зарлага 1,8 их наяд төгрөгөөр нэмэгдэх бөгөөд нэгдсэн төсвийн нийт алдагдал 1,6 их наяд төгрөг буюу анх батлагдсан Дотоодын нийт бүтээгдэхүүний 2,6 хувиас хэтрүүлэхгүй байхаар төлөвлөлөө.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Т.Энхтүвшин: Булгантуяа сайдад баярлалаа.

Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Наранчимэг танилцуулна. Наранчимэгийн микрофоныг өгөөрэй.

Ц.Наранчимэг: Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Монгол Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу төрийн аудитын байгууллага дараах дүгнэлтийг гаргаж байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 20 их наяд 781,9 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 34,5 хувь, нийт зарлагын хэмжээг 22 их наяд 371,4 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 37,2 хувь, төсвийн алдагдлыг 1 их наяд 589,5 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2,6 хувь байхаар төлөвлөжээ.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2023 оны төсвийн тодотголд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөвт дараах өөрчлөлтүүдийг оруулсан байна.

Барилга, хот байгуулалтын сайдын төсөв 2023 оны батлагдсан төсвөөс 7,8 тэрбум төгрөгөөр, Уул уурхайн сайдын төсөв 2,1 тэрбум, Зам, тээврийн хөгжлийн сайдын төсөв 1,8 тэрбум, Эрчим хүчний сайдын төсөв 0,9 тэрбум, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн

үйлдвэрийн сайдын төсөв 10 тэрбум төгрөгөөр тус тус өөрчлөлт орсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын урсгал зардлын төсөв 22,6 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд, төрийн албан хаагчдын цалин хөлсний системийг шинэчлэн цалинг нэмэгдүүлж тогтоосон нь голлон нөлөөлжээ.

Төрийн аудитын байгууллага Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна гэж дүгнэж байна. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Т.Энхтүвшин: Наранчимэгт баярлалаа.

Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын төсөл болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн талаарх товч танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээ хэлтсээс та бүхэнд бас ирүүлсэн байж байгаа.

Хууль санаачлагч болон Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчаас асуулт асуух гишүүн байна уу? Гишүүд нэрээ өгье. Цогтгэрэл гишүүнээр тасаллаа. Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Би нэг 3 асуулт асууя.

1 дүгээрт, энэ Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсээс бэлдсэн энэ материал дотроос яг энэ үйлдвэржилттэй холбогдуулж тодруулахад орлогын албан татвар 645 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр өсөхөөр байна. НДШ хураамж 192 тэрбум төгрөгөөр өсөхөөр байна. Хамгийн

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ноцтой нь, нэмэгдсэн өртгийн албан татвар 241,9 тэрбум төгрөгөөр өсөхөөр байна гэж байгаа юм. Тэгэхээр эндээс миний тодруулж асуух гээд байгаа зүйл гэвэл НӨАТ өсөх үү, хөдлөх үү гэдэг асуулт байна. Энэ үйлдвэрлэгч, бизнес эрхлэгч нарт ямар нөлөө учрах вэ, үзүүлэх вэ? Хуудас 4 дээр байгаа шүү. Би энэ хуудас 6-г харж ярьж байна. Хуудас 4 дээр импортын нэмэгдсэн өртгийн албан татвар 14 хувиар, төсвийн орлогын өсөлтийн 14 хувийг бүрдүүлнэ гээд үг явж байна. Тэгэхээр НӨАТ төсвийн орлогын өсөлтийн 14 хувийг бүрдүүлнэ гэж ингэж ойлгож байна. Энэ өсөлт үйлдвэрлэгч, бизнес эрхлэгч, жирийн хүмүүс дээр яаж буух вэ? НӨАТ нэмэгдэх үү? Хэдэн хувиар 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт. Ер нь би чуулган дээр ч гэсэн тодруулж асуусан. Яах вэ, манай Орхон аймаг төсөвт мөнгө өгдөг 5 аймгийн нэг учраас манай аймгийн тухай би асуусангүй. Зүгээр энэ санхүүгийн дэмжлэг өгөхдөө 3 том үзүүлэлт байгаа. Сумын тоо, хүн ам, газар нутаг. Тэгээд Хөвсгөл хамгийн том байна л даа 26 тэрбум 775 сая төгрөг. 24 сумтай, үнэн. Хамгийн том сумуудын нэг байна. 136 мянган хүн амтай байна. 1600 км квадрат гээд биччихсэн байна, 26 тэрбум 775 сая төгрөг гэж байна.

Ард нь Хэнтий 17 сум, энэ маш бага сум. Хэнтийнхэн намайг өршөөнө биз, зүгээр би яагаад алагчилж байгаа юм бэ л гэж асуух гээд байна. Хүн ам 78 мянга, газар нутаг 80 мянга, тэгээд 25 тэрбум төгрөг байна. Хамгийн том нь 26 тэрбум байна. Хамгийн одоо энэ бол 25. Ингээд цаашид ярих юм бол би олон сумнуудыг Завхан байна. Хүн ам 71 мянга, газар нутаг 82500, тэгэхэд 23 тэрбум байна. Тэгээд энэ тооцоолуурыг надад цаасаар өгнө өө гэсэн. Би Байнгын хороо юу Их Хурлын чуулган дээр ярьсан, одоо хүртэл аваагүй байгаа. Энэ асуултаа би бас дахиад тодруулаад асууя. Ямар алагчилсан нүдээр үүнийг хийсэн бэ гэж би асуух гээгүй. Ямар гоё шударга, гоё

нүдээр энийг хийсэн бэ? Тэр тооцоолуураа танилцуулах боломж байна уу?

Т.Энхтүвшин: Ганбаатар сайд ямар мэдээлэл уншихав. Албан ёсны мэдээлэлтэй. Чуулган дээр өгсөн мэдээллийг уншаад байх шиг байна. Тийм ээ.

С.Ганбаатар: Тийм.

Т.Энхтүвшин: Ажлын хэсэг. Жавхлан сайд хариулах уу. Орон нутгийн хөгжлийн сантай холбоотой юм асуугаад байх шиг байна. Нэмэгдсэн өртгийн албан татвартай холбоотой асуудлыг. Жавхлан сайдын микрофоныг өгөөрэй.

Б.Жавхлан: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Тэгээд орон нутгийн хөгжлийн сангийн хуваарилалт ерөөсөө ямар ч тийм үзэмжийн асуудал байхгүй байна шүү дээ, Ганбаатар гишүүн ээ. Шууд томъёогоор байхгүй юу, томъёогоор автомат тавигдаж байгаа тоо. Тэгээд тэндээс манай Санжаа дарга тодруулаад хэлчхээрэй.

НӨАТ, импортын НӨАТ-ын энэ орлогууд бүгд нэмэгдэнэ. Бид энэ жил гол орлого болох түүхий эдүүдийн экспорт нэмэгдэнэ гэж тооцож байгаа. Гол орлогын нөлөөлөл тэндээс байгаа. Үүнтэй холбоотой болон цалин, тэтгэвэр, тэтгэмжүүд нэмэгдэж байгаатай холбоотой НӨАТ-ын татвар, НӨАТ-ын орлогууд нэмэгдэнэ, нийгмийн даатгалын орлого нэмэгдэнэ. Шимтгэлийн орлогууд энэ нөгөө цалин, тэтгэмжээ дагаад нэмэгдэх учраас тэр тоонууд л юм байгаа юм шүү. Тэгээд тэр орон нутгийн хөгжлийн сангийн хуваарилалтын томъёоллыг яаж бүрддэг вэ? Түүнийг тодруулаад тэгээд аймаг, аймгийнх ямар байна вэ хэлээдхээрэй.

Т.Энхтүвшин: Ажлын хэсэг Санжаа хариулах уу? Санжаадорж ажлын хэсгийн микрофоныг өгөөрэй.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Орон нутагтаа улсын төсөв 2 тоогоор харилцаа байдаг. Эхнийх нь татаас орлогын шилжүүлэг. Энэ бол тухайн аймгийн эдийн засгийн чадавхаасаа шалтгаалаад хэр хэмжээний зарлага гарч байна, орлого олж байна. Энэ 2-ын зөрөөгөөр татаасны асуудал яригддаг.

2 дахь асуудал нь яг таны асуудаг асуудал бол орон нутгийн хөгжлийн сангийн тооцооллын асуудал байгаад байгаа. Тэгэхээр орон нутгийн хөгжлийн сан өөрөө Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн дагуу 3 итгэлцүүрээр хуваарилагддаг. Үүнийх нь дагуу орж ирсэн мөнгө нь хуваарилагддаг. Эх үүсвэр нь өөрөө хайгуулын тусгай зөвшөөрлийн 100 хувь, ашиглалтын тусгай зөвшөөрлийн 50 хувь гэх мэт АМНАТ-ын мөн 10 хувийн ийм орлогын эх үүсвэрээс бүрддэг. Үүнийх нь дагуу тооцооллууд нь хийгдэж явдаг байгаа. Ямар нэгэн байдлаар орон нутгийн хөгжлийн сан дээр хувь хүний тийм хамаарсан тооцоолол байхгүй. Бүгд томъёогоор бодогддог. Томъёотой холбоотой хэсгийг Төсвийн байнгын хорооны ажлын албанд хүргүүлсэн байгаа. Төсвийн байнгын хорооны ажлын албанаас сонирхсон гишүүдэд танилцуулна гэж бидэнд мэдэгдсэн. Шууд бид Засгийн газрын зүгээс гишүүдэд мэдээлэл өгөхгүйгээр Төсвийн байнгын хороогоор дамжуулах юм байна гэж ойлгоод тэнд мэдээлэл өгсөн байгаа гишүүд ээ, баярлалаа.

Т.Энхтүвшин: НӨАТ сая хариулчихсан байх. Хариулчихсан шүү. Юу яасан байна шүү, Ганбаатар сайд аа. Ганбаатар гишүүн ээ, орон нутгийн хөгжлийн сан дээр танайх 3,4 тэрбум төгрөг нэмэгдсэн юм байна шүү дээ. Энэ нөгөө итгэлцүүрээр ингээд бодоод гаргадаг. АМНАТ, лицензийн төлбөр, хайгуулын төлбөр гээд. Үүгээр гаргадаг ийм орлого шүү дээ.

Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр улс орны эдийн засагт нааштай жоохон өөрчлөлтүүд гарч, орлогын бүрдэл бас хүлээгдэж байгаа гүйцэтгэлээрээ нэлээн бололцоотой гарах ийм төлөв байгаад байгаа юм. Тийм учраас энэ хүнд цаг үед иргэдийн амьжиргааг дэмжих, цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжээ нэмэгдүүлэх энэ бодлогын чиглэлийг авч хэрэгжүүлж гэж ерөнхий шийдэлд хүрч энэ асуудал явж байгаа. Тийм учраас энэ бол зүйн хэрэг ээ гэж. Зүгээр эртээд бид нар ярьж байхад ерөнхий мэргэжлийн гэдэг юм уу, мэргэжлийн чиг үүрэг хэрэгжүүлээд байгаа төрийн албан хаагчдыг заавал ТЗ ангиллаар байх уу үгүй юү энэ тэр гэдэг юмыг зөв зохицуулъя энэ тэр гээд яригдаад байсан. Тэр ер нь ангилал юмнууд хийгдэж чадсан юм уу гэдэг асуудал байна. Жишээ нь энэ сумдын Хөдөө аж ахуйн тасгууд, мал эмнэлгийн тасгуудын албан хаагчид ТЗ ангиллаар яваад байгаа байхгүй юу. Тэр бол ер нь ТҮ ангиллаараа явж байх ёстой. Таны яриад байснаар өнөө мэргэжлийн үйлчилгээ үзүүлж байгаа л байгууллага шүү дээ. Тэгэхээр энэ өөрчлөгдөж чадсан уу гэдэг нэг ийм зүйл байна гэж.

2 дахь зүйл. 256,3 тэрбум төгрөгөөр хөрөнгө оруулалт нэмэгдсэн байна. Тэгэхээр үүнийг чухам юунд чиглүүлж нэмэв. Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулахад чиглэгдлээ гэж ойлгогдож байгаа юм шиг байгаа юм. Танилцуулгаас уншихаар зэрэг. Чухам ямар арга хэмжээнүүд байна вэ гэдэг ийм 2 зүйл дээр хариулт авъя. Баярлалаа.

Т.Энхтүвшин: Ажлын хэсэг хэн хариулах вэ? Булгантуяа сайд. Сумдад ажиллаж байгаа Хөдөө аж ахуйн мэргэжилтнийг ТЗ-ээр

Х.Булгантуяа: Батжаргал даргын асуултад хариулъя. Мал эмнэлгийнхэн гэх мэт энэ ангилал зэрэглэлийн хувьд бид нар үүгээр бас

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

салбарын яамных нь саналыг сонсож байж энэ хүсэлтийнх нь дагуу ангилал зэрэглэлийг өөрчлөх асуудлыг шийдэх нь зүйтэй гэж үзэж байгаа. Тамгын газарт нь байгаа хүмүүс нь төрийн захиргааныхан байгаа. Ер нь яах вэ аймаг, орон нутгуудаас зарим салбаруудад үнэхээр нарийн мэргэжлийн хүмүүс, аймаг орон нутаг, төрийн захиргаа дээр өндөр шаардлага тавьдаг, шалгалт өгдөг, түүн нь тэнцдэг хүмүүс сум, орон нутагт олдоход бас хэцүү байна гэдэг ийм үндэслэлээр жишээлбэл БОАЖЯ ойн хамгаалагчдынхаа хувьд ТЗ-ийн ангилал дээр хүнд байна гээд өөрсдөө санал тавиад, жишээлбэл ТҮ-рүү шилжүүлсэн юм. Тэгэхээр яг салбарын яамдаас нь тийм саналууд ирээгүй байвал нэмж бид нар өөрсдөө ангиллаас ангилал руу тусгайлан түүнийг нь тэр тусмаа төрийн захиргаанаас ТҮ рүү ч байдаг юм уу шилжүүлэх ийм юу бол хийгээгүй байгаа. Тэгэхдээ Тамгын газарт байгаа хүмүүс нь тэр нь Төрийн захиргаа, анхан шатан дээр ажиллаж байгаанууд нь Алимаа дарга ТҮ биш биз дээ? Бүгд ТЗ, тийм бүгд ТЗ. Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас энэ асуудлаар бид нарт ТҮ болгоё гэж хандаагүй.

Т.Энхтүвшин: 2 дахь асуудал Жавхлан сайд.

Б.Жавхлан: 256 ч биш дээ, 187 нь нийслэл дээр. Батжаргал гишүүний асуултад хариулъя. Хөрөнгө оруулалт яах вэ, 187 чинь бас шууд улсын төсвийн хөрөнгө оруулалт биш. Эндээс нийслэл рүү энэ нийслэлийн төсөв рүү зохицуулалт хийж, ноднин эхэлсэн төсөвт өртөг нь 420 тэрбумын өртөгтэй 11 төсөл байгаа, 11 том төсөл байгаа. Энэ нь нөгөө нэг жижиг замуудын холболт, том замууд ч байгаа. Газар чөлөөлөлтийн ажлууд байгаа. Ноднин эхлүүлсэн ажлаа гүйцэтгэл нь 420-оос 187 гэхээр нөгөө 233 байсан гүйцэтгэл нь. Тэгээд ингээд энэ жилийнхийг гүйцээж дуусахаар 187 тавигдаж байгаа гэж ойлгоорой.

Өөр нэг хөрөнгө оруулалт нь юу байгаа. Хойтон сонгуульд зориулсан СЕХ болон УБЕГ дээр сонгуулийн нөгөө бидний автомат машин, мөн хуруу унших төхөөрөмжүүд гээд нийтдээ 38 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт байгаа. 256 бол байхгүй шүү.

Манайхаас Дэлгэржаргал нэмээд хариулаадах.

Т.Энхтүвшин: Ажлын хэсэг нэмээд хариулах уу? Дэлгэржаргал ажлын хэсгийн микрофоныг өгөөрэй.

Гишүүний асуултад хариулъя. Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Дэлгэржаргал. Сайдын сая хэлсэнчлэн яг улсын төсвийн хөрөнгө оруулалт дээр 2 төсөл, арга хэмжээ нэмэгдэж байгаа. Шинээр Сонгуулийн ерөнхий хороо дээр тоног төхөөрөмж, Улсын бүртгэл дээр мөн сонсогчийн бүртгэлийн тоног төхөөрөмж. Өөр ямар нэгэн төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалт нэмэгдээгүй байгаа.

Мөнгөн дүн эд нар нэмэгдээгүй, төсөл нэмэгдээгүй. Яг саяын 2 өөрчлөлтөөс өөр өөрчлөлт байхгүй байгаа.

Т.Энхтүвшин: 256,6 гээд байж байна шүү. Нэмж яах уу?

Цогтгэрэл гишүүн асуултаа асууя.

О.Цогтгэрэл: Энэ төсөв хэлэлцэх болгонд нэг ангилал, категори нь тогтдоггүй нэг зүйл байгаад байгаа юм. Энэ хүүхдийн мөнгө. 20-оод жилийн өмнө анх гарахдаа энэ бол байгалийн баялгийг ард иргэддээ хүүхдээр дамжуулж тэгш хүртээх арга зам юм. Энэ хүн хүн амаа өсгөх бодлого юм гэдэг томъёоллоор анх төсөвт орж ирж байсан ийм зүйл хүүхдийн мөнгө гэдэг нэрээр. Сүүл рүүгээ явсаар байгаад энэ өөрөө тийм халамж юм. Боломжгүйд нь өгдөг, боломжтойд нь ялгаад өгөхгүй байдаг халамж юм гэж

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

байсан. Одоо орж ирэхэд энэ төсөв дээр яг аль ангиллаар нь орж ирж байгаа юм бэ? Бүгдэд нь өгөх гэж байгааг бодохоор байгалийн баялаг, хүртээмж, хүн амаа өсгөх бодлого юм шиг. Хүсэлт гаргасанд нь өгнө. Заримд нь өгөхгүй, заримд нь өгнө гэж байгааг бодоход энэ халамж юм шиг. Тэгэхээр одоо энэ хүүхдийн мөнгө яг аль ангилалд байгаа. Ер нь энэ Засгийн газрын бодлогод өөрөө хүүхдийн мөнгийг ер нь юу гэж томъёолж байгаа юм? Энэ халамж юм уу. Энэ өөр тэр байгалийн баялгийн хөрөнгө оруулалт нь юм уу. Хүн амын өсөх бодлого нь юм уу? Энэ өөрөө асар том дүнтэй хэдэн их наядаар яригдах дүнтэй нэг ийм бодлогын асуудал, тал тал руу ингээд үсчсэн, тал тал дээр ингээд зүгээр л нэг ийм Засгийн газрын арга хэрэгсэл тал руугаа явчхаад байна л даа. Үүн дээр нэг ийм тодорхой хариулт өгөөч.

Т.Энхтүвшин: Ажлын хэсэг Жавхлан сайд, Булгантуяа сайд хариулъя. Хүүхдийн мөнгөтэй холбоотой асуудал халамж юм уу гээд асуугаад байна.

Х.Булгантуяа: 23 оны төсөв дээр халамж гэдэг юун дээр явж байгаа, төсөв дээр. Одоо нэмэгдэл нь ч гэсэндээ бас халамж дээр нэмэгдэж орж ирж байгаа гэсэн үг. Тийм учраас яах вэ, бид нар сая ингээд нөхөн олгоно. Дээрээс нь би 07 сарын 01-нээс бүх хүүхдүүд бас олгохоор төсвийг нь бид нар тавьж өгсөн. Гэхдээ яах вэ, иргэдийн хувьд бас авах, авахгүй гэдэг сонголтыг нь бас бий болгоё. Өмнө нь хүмүүс бас 100 хувь олгож байхад 10 хувь нь авдаггүй, бүртгүүлдэггүй байсан бас ийм юмнууд байгаа. Тэгэхээр энэ сонголтыг нь бас иргэдэд нь олгоё. Ер нь яах вэ, сая Ерөнхий сайд бас төсвийн өргөн барихад Улсын Их Хурлын чуулган дээр бас хэлж байсан. Цаашид бид нар хүүхдийн мөнгийг бас тодорхойлох ёстой. Энэ эс үгүй бол халамж юм уу, эс үгүй бол байгалийн баялгийн хуваарилалт юм уу. Ямар яг категориор явах юм бэ, зардлаар явах юм бэ гэдэг дээрээ бид нар бас харах ёстой гэсэн. Тэгээд хэн Цогтгэрэл дарга яг чухал л асуудлыг нь хөндөж байна л даа.

Яг энэ жилдээ халамж гэдгээр явж байгаа гэсэн үг.

Т.Энхтүвшин: Болсон уу.

Гишүүд хууль санаачлагч болон Байнгын хорооны өөрийн эрх асуудлын хүрээнд хамаарах асуулт асууж, хариулт авч дууслаа.

Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын төсөлтэй холбогдуулан зарчмын зөрөөтэй санал гаргах гишүүд байна уу? Алга байна.

Төсвийн тодотголын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Батжаргал гишүүн Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

16.41 цаг

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тулд өнөөдрийн хуралдааныг хааж байна.

Эрхэм Улсын Их Хурлын гишүүндээ бас баярлалаа.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ